



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/197

Булган сум

Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн
томилох, ажиллах журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт “Улсын Онцгой комиссын ажиллах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Онцгой комиссын ажиллах журмыг 2 дугаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, ажил үүргийн хуваарийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/222 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
02-дугаар сарын 15-ны өдрийн А/07-дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



Комиссын дарга
Орлогч дарга
Гишүүд:

Аймгийн Засаг дарга
Онцгой байдлын газрын дарга
Аймгийн Засаг даргын орлогч
Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Мал эмнэлгийн газрын дарга
Цагдаагийн газрын дарга
ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
“Булган мээж” ОНӨХХК-ийн захирал /шаардлагатай үед/
Булган сумын Засаг дарга
“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Булган аймгийн
газрын дарга /шаардлагатай үед/
“Эрдэнэт-Булган” Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн
Булган аймаг дахь салбарын дарга /шаардлагатай үед/
“Булган АЗЗА” ТӨХК-ийн захирал /шаардлагатай үед/
Булган аймаг Авто тээврийн төвийн дарга
/шаардлагатай үед/
Булган Улаан загалмай хорооны дарга
/шаардлагатай үед/
Нарийн бичгийн дарга: Онцгой байдлын газрын орлогч дарга

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймгийн Онцгой комисс (цаашид “комисс” гэх) Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлт, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний аюулаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд өөрийн хүч хэрэгсэл, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх бололцоогүй болж тусламж, дэмжлэг үзүүлэх талаар албан ёсны хүсэлт тавьсан буюу өөрийн санаачилгаар хүн хүч, техник хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан, шуурхай зохицуулах, хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

3. Аймаг, сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны Засаг дарга батална.

4. Гамшиг, аюулт үзэгдлийн төрлөөс хамааран эрхэлсэн салбар, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс оролцуулан /Онцгой комиссын гишүүдээс/ ажлын хэсэг байгуулж болно.

5. Комиссыг аймгийн Засаг дарга тэргүүлнэ. Комиссын даргын эзгүйд түүнийг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой байдлын газрын дарга нар орлоно. Нэгэн зэрэг эзгүйд эрхэлсэн ажлын хүрээнд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан томилгоожсон ажлын хэсгийн дарга /хариуцсан агентлаг, хэлтсийн дарга/ орлоно.

6. Комиссын хурал нийт гишүүдийн 50-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

7. Комисс нь холбогдох хууль тогтоомж, энэ журмаар олгогдсон үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар тушаал, албан даалгавар гаргаж болно.

8. Үүссэн цагийн байдалтай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн анги, холбогдох байгууллагын удирдлагуудыг оролцуулсан комиссын өргөтгөсөн хурал хийж болно.

9. Комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

10. Комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин, гамшиг, аюулт үзэгдэл, осолд шаардлагатай эд зүйлийн нөөцтэй байх бөгөөд Онцгой комиссын ажлын албаны үүргийг Онцгой байдлын газар гүйцэтгэнэ. Өдөр тутмын ажлыг орон тооны бус нарийн бичгийн дарга буюу Онцгой байдлын газрын орлогч дарга эрхэлнэ.

11. Онцгой комиссын гишүүд үнэмлэх, шаардлагатай тохиолдолд гамшиг, аюулт үзэгдлийн голомтод шуурхай хариу арга хэмжээ авахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байж байна.

Хоёр: Комиссын үүрэг, эрх

2.1. Комисс дараах үүрэгтэй байна.

2.1.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны болон байгууллага, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх, Засгийн газрын шийдвэр, Улсын Онцгой комиссоос энэ чиглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.1.3. Гамшигтай тэмцэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, арга туршлагыг судлах, харилцан солилцох.

2.1.4. Гамшгийн цагийн байдалд өгсөн үнэлэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай яам Засгийн газрын агентлагаас ирүүлсэн үүрэг, орон нутгийн агентлаг, сумаас ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах.

2.1.5. Гамшиг бүхий нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас дайчлан гаргасан эд хөрөнгө, нөхөн төлбөр, зардлын талаар гамшиг, аюулт үзэгдэл үүссэн тухайн сум, байгууллагын гаргасан тооцоог үндэслэн санал боловсруулж аймгийн Онцгой комисс, Улсын Онцгой комисс, холбогдох яам, агентлагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

2.1.6. Гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх.

2.1.7. Гамшгийн голомтод хуваарилан олгосон бараа, материал, бусад тусламжийг хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих.

2.1.8. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай

хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах санал боловсруулан зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

2.1.9. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

2.1.10. Аймгийн Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.

2.1.11. Аймгийн Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүрд нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Улсын онцгой комисст танилцуулна.

2.2. Комисс дараах эрхтэй байна.

2.2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.2.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

2.2.3. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий шуурхай бүлгийг томилон ажиллуулах.

2.2.4. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж, шийдвэр гарган ирүүлэхийг шаардах.

2.2.5. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

2.2.6. Гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд зэвсэгт хүчин болон бусад хүчний байгууллагуудын анги салбарын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг дайчлан ажиллуулах талаар Улсын онцгой комисст санал тавих.

2.2.7. Гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах зардал болон бараа материал, тоног

төхөөрөмж гаргах, яаралтай авах арга хэмжээний талаарх саналыг асуудал эрхэлсэн дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх.

2.2.8. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах.

2.2.9. Аймаг, сумын Онцгой комисс нь Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт “Улсын Онцгой комиссын ажиллах журам”-ын 2.1.1, 2.1.2, 2.1.4, 2.1.7, 2.1.8-д заасан үүргийг биелүүлэн, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.7-д заасан эрхийг эдэлнэ.

2.3. Комиссын гишүүн дараах үүрэгтэй байна.

2.3.1. Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах, гамшгийн голомт буюу хорио цээрийн дэглэм тогтоосон газарт зохих журмын дагуу нэвтэрч үйл ажиллагааг нь шалгаж, заавар зөвлөгөө өгөх.

2.3.2. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам, Комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хянаж шалгах.

2.3.3. Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөмж өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөмж өгөх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын дарга, комисст албан ёсоор танилцуулах.

2.4. Комиссын гишүүн дараах эрхтэй байна.

2.4.1. Аймаг, сумын гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай бол комиссын хуралд асуудал танилцуулж, авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх.

2.4.2. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэх асуудлаар аймаг, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэх.

2.4.3. Онцгой комиссын гишүүн нь нутаг дэвсгэртээ байгаль цаг агаарын аюулт үзэгдэл, гамшиг осол тохиолдсон үед ажил үүргийн шаардлагын улмаас үйлчилгээний байгууллагуудад дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ. Комиссын гишүүний ажил үүргийн холбогдолтой тавьсан шаардлагыг тухайн албан тушаалтан, иргэд биелүүлнэ.

Гурав: Комиссын зардал

3.1. Аймгийн Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг

хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг тухайн жилийн төсөвт туссан хөрөнгө /Засаг даргын нөөц хөрөнгө, бусад/, гамшгийн санд хуримтлагдсан хөрөнгөөс зориулалтын дагуу зарцуулна. Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгохтой холбоотой зардлыг мөн Улсын онцгой комисст асуудал тавьж шийдвэрлүүлнэ.

Дөрөв: Бусад зүйл

4.1. Өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ноогдуулах саналаа комисс, эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

--- оОо ---



ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮТЭЦ

| Д/д | Ажлын хэсгийн нэр | Ажлын хэсгийн ахлагч | Бүрэлдэхүүний тоо |
|--|---|--|-------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| Нэг. Ажлын хэсгийн бүтэц | | | |
| 1 | Хүч хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюултай тэмцэх ажлын хэсэг | Аймгийн Засаг даргын орлогч | 13 |
| 2 | Үер, хөдлөлтийн аюултай тэмцэх ажлын хэсэг | АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга | 10 |
| 3 | Объектын болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсэг | Онцгой байдлын газрын дарга | 9 |
| 4 | Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрийн үед ажиллах ажлын хэсэг | Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга | 9 |
| 5 | Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг | Эрүүл мэндийн газрын дарга | 7 |
| 6 | Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг | Мал эмнэлгийн газрын дарга | 7 |
| 7 | Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсэг | АЗДТГ-ын Цэргийн штабын дарга | 7 |
| 8 | Эрчим хүчний эрсдэлтэй тэмцэх ажлын хэсэг | АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга | 5 |
| Хоёр. Хүч хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюулын үед ажиллах ажлын хэсэг | | | |
| д/д | Албан тушаал, томилгоо | | |
| 1 | Хүч, хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюултай тэмцэх ажлын хэсгийн дарга | | |
| 2 | Онцгой байдлын газрын дарга | | |
| 3 | АЗДТГ-ын дарга | | |
| 4 | АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга | | |
| 5 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга | | |
| 6 | Цагдаагийн газрын дарга | | |
| 7 | Эрүүл мэндийн газрын дарга | | |
| 8 | Булган аймаг авто тээврийн төвийн дарга | | |
| 9 | Булган "АЗЗА" ТӨХК-ний захирал | | |
| 10 | "Булган Мээж" ОНӨХХК | | |
| 11 | ЭБЦТСТӨХК-ний Булган салбарын дарга | | |
| 12 | Булган сумын Засаг дарга | | |
| 13 | АЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний албаны дарга | | |
| Хоёр. Үер, хөдлөлтийн аюулын үед ажиллах ажлын хэсэг | | | |
| 1 | Үер, хөдлөлттэй тэмцэх ажлын хэсгийн дарга | | |
| 2 | Онцгой байдлын газрын дарга | | |
| 3 | Цэргийн штабын дарга | | |
| 4 | Эрүүл мэндийн газрын дарга | | |

| | |
|---|---|
| 5 | Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газрын дарга |
| 6 | "Булган Мээж" ОНӨХХК-ний захирал |
| 7 | Цагдаагийн газрын дарга |
| 8 | ЭБЦТСТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга |
| 9 | Булган "АЗЗА" ТӨХК-ний захирал |
| 10 | Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга |
| Гурав. Объектын болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсэг | |
| 1 | Объектын болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсгийн дарга |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| 3 | Цагдаагийн газрын дарга |
| 4 | Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга |
| 5 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| 6 | Эрүүл мэндийн газрын дарга |
| 7 | Булган аймаг авто тээврийн төвийн дарга |
| 8 | Булган сумын Засаг дарга |
| 9 | Гал түймэр унтраах, аврах 20-р ангийн захирагч |
| Дөрөв. Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрийн аюулт үзэгдлийн үед ажиллах ажлын хэсэг | |
| 1 | Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрийн аюулт үзэгдлийн үед ажиллах ажлын хэсгийн дарга |
| 2 | Онцгой байдлын газрын дарга |
| 3 | Цагдаагийн газрын дарга |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| 5 | Мал эмнэлгийн газрын дарга |
| 6 | Эрүүл мэндийн газрын дарга |
| 7 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| 8 | "Булган-АЗЗА" ТӨХК-ний захирал |
| 9 | ЭБЦТСТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга |
| Тав. Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг | |
| 1 | Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсгийн дарга |
| 2 | Онцгой байдлын газрын дарга |
| 3 | АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| 4 | Цагдаагийн газрын дарга |
| 5 | ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга |
| 6 | Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга |
| 7 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга |
| Зургаа. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг | |
| 1 | Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсгийн дарга |
| 2 | Онцгой байдлын газрын дарга |
| 3 | Цагдаагийн газрын дарга |
| 4 | ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга |
| 5 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| 7 | Эрүүл мэндийн газрын дарга |
| Долоо. Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсэг | |
| 1 | Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсгийн дарга |
| 2 | Онцгой байдлын газрын дарга |
| 3 | АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| 4 | Цагдаагийн газрын дарга |
| 5 | Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| 7 | ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга |

| Найм. Эрчим хүчний эрсдэлтэй тэмцэх ажлын хэсэг | |
|--|--|
| 1 | АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| 2 | Онцгой байдлын газрын дарга |
| 3 | Эрдэнэт-Булган ЦТСүлжээ ТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга |
| 4 | “Булган Мээж” ОНӨХХК-ний захирал |

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн А/97 дугаар
захирамжийн 4 дүгээр хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Зорилго: Аймгийн Онцгой комиссын гишүүд мэргэжлийн чиглэлээр болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, гарсан үед шуурхай хариу арга хэмжээ авахад чиглэгдэнэ.

| Д/д | Албан тушаал | Томилгоот албан тушаал | Ажил үүргийн хуваарь |
|-----|-----------------------------|------------------------------|---|
| 1 | Аймгийн Засаг дарга | Онцгой комиссын дарга | <ul style="list-style-type: none">- Нутаг дэвгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх- Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газрын шийдвэр, Улсын Онцгой комиссоос өгсөн үүргийг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хууль тогтоомж, өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих- Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах- Гамшигтай тэмцэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, арга туршлагаа харилцан солилцох;- Гамшгийн цагийн байдалд өгсөн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох албадын илтгэл мэдээллийг хэлэлцэж шийдвэр гаргах- Гамшиг бүхий нутаг дэвсгэр, тухайн бүсийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах- Гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол, дайчлан гаргасан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн асуудлаар гамшиг үүссэн тухайн сумын гаргасан тооцоог үндэслэн санал боловсруулж Улсын Онцгой комисст хүргүүлэх, аймаг, сумын Онцгой комиссоор шийдвэрлүүлэх- Гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссын хурлыг зохион байгуулж холбогдох шийдвэрийг шуурхай гаргаж хэрэгжүүлэх- Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий шуурхай бүлгийг томилон ажиллуулах- Аймгийн Засаг дарга, орлогч даргын эзгүйд Онцгой комиссыг удирдана |
| 2 | Онцгой байдлын газрын дарга | Онцгой комиссын орлогч дарга | |

| | | | |
|---|-----------------------------|---|---|
| | | | <ul style="list-style-type: none"> - Гамшиг, аюулт үзэгдэл үүссэн цагийн байдал, орон нутгаас ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, аймгийн Онцгой комиссыг мэдээллээр хангах, эрх бүхий байгууллага болон холбогдох албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах - Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын бүлэг, сумын удирдлагыг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангана - Сум, байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс Онцгой комисст ирүүлсэн хүсэлт, өргөдлийг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч, гамшиг, аюулт үзэгдлээс үүдэлтэй эд хөрөнгийн болон зардлын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх асуудлыг Засаг дарга, Онцгой комиссын гишүүдэд тавьж шийдвэрлүүлнэ - Аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллах - Гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах ажил явуулахад шаардагдах хүн, хүч, техник болон холбоо мэдээллийн хэрэгсэл, бараа материалаар хангах, нөөц бүрдүүлэх, хадгалах ажлыг зохион байгуулна - Аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гүйцэтгэх үүрэг, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож удирдлагаар ханган ажиллах - Гамшгаас хамгаалах тухай хууль, Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэр, Онцгой байдлын ерөнхий газраас өсгөн үүргийн биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллах - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах |
| 3 | Аймгийн Засаг даргын орлогч | Онцгой комиссын гишүүн, гамшгаас хамгаалах штабын дарга | <ul style="list-style-type: none"> - Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах, гамшгийн голомт буюу хорио цээрийн дэглэм тогтоосон газарт зохих журмын дагуу нэвтэрч үйл ажиллагааг нь шалгаж, заавар зөвлөгөө өгөх - Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах - Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах - Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих - Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцүүлж, шийдвэр гарган биелүүлэхийг шаардах - Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах - Аймаг, сум, хариуцсан албаны гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай бол комиссын хуралд асуудал танилцуулж авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх |

| | | |
|---|---|---|
| | | <p>- Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэх асуудлаар тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэх</p> <p>- Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна.</p> <p>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлаа хангах</p> |
| 4 | <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга</p> <p>Онцгой комиссын гишүүн, гамшгаас хамгаалах асуудал хариуцсан туслах</p> | <p>- Аймгийн Онцгой комиссын удирдлага штабын байрыг хариуцаж гамшгаас хамгаалах албад, штабын бүрэлдэхүүнийг ажиллуулах байр, холбооны хэрэгсэл, хоол, унаагаар хангахад удирдлагаар хангах</p> <p>- Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах</p> <p>- Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах</p> <p>- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлууллгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих</p> <p>- Аймгийн Засаг даргын тамгын газрын гамшгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;</p> <p>- Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна.</p> <p>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах</p> <p>- Хурал зарласан үед яаралтай заагдсан газар ирэх</p> |
| 5 | <p>Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга</p> <p>Онцгой комиссын гишүүн, гамшгаас хамгаалах асуудал хариуцсан туслах</p> | <p>- Аймгийн Онцгой комиссын удирдлага штабын байрыг хариуцаж гамшгаас хамгаалах албад, штабын бүрэлдэхүүнийг ажиллуулах байр, холбооны хэрэгсэл, хоол, унаагаар хангахад удирдлагаар хангах</p> <p>- Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах</p> <p>- Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах</p> <p>- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлууллгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих</p> |

| | | | |
|---|---|--|---|
| | | | <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын Тамгын газрын гамшгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах; - Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна. - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах - Хурал зарласан үед яаралтай заагдсан газар ирэх - Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах - Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах. - Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах - Хурал зарласан үед яаралтай заагдсан газар ирэх - Гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардагдах нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудлыг нэгтгэн, тухайн онд батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайлан, санхүүгийн анхан шатны материалын хамт Улсын онцгой комисст хүргүүлж шийдвэрлүүлэх - Гамшиг осол, аюулт үзэгдлийн үед цагийн байдал хүндэрч тухайн орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд авах арга хэмжээний шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тухай бүр шийдвэрлэх саналыг боловсруулж, танилцуулах - Гамшгийн үед үүссэн хохирлын мэдээг үнэн зөв гаргаж үүрэг гүйцэтгэж байгаа ажлын хэсэг, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, шлабын нэгжүүд, сайн дурын бүлэг, голомтын бүсэд байгаа нэрвэгдэгсдэд шаардагдах техник, багаж хэрэгсэл, эм тариа, хүнс, өргөн хэрэглээний бараа, орон байр, бусад материал зэрэг хангалтыг нэн яаралтай зохион байгуулж хуваарилах, тээвэрлэн хүргэх, тэдгээрийн ашиглалтын байдалд хяналт тавих ажлыг дэс дараатайгаар шийдвэрлэх - Гамшгийн голомтод гамшиг осол, аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд туслах зорилгоор төрийн болон хувийн байгууллага, иргэдээс дайчлан гаргасан хүн, хүч техник, багаж хэрэгсэл, эд материалын тооцоог баримтаар нотлогдох зардлыг үндэслэн төлбөр хийх ажлыг шуурхай зохион байгуулах - Олгосон төсөв санхүүжилтэнд хяналт тавьж, Онцгой комиссын хуралд мэдээлж байх - Онцгой комиссын шийдвэрийн төслийг боловсруулах, хууль зүйн үндэслэлийг тогтоон шийдвэрийг гаргаж, биелэлтийг хангуулж хяналт тавих |
| 6 | Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | Онцгой комиссын гишүүн, хангалт хариуцсан туслах | |
| 7 | Аймгийн ЗДТГ-ын | Онцгой комиссын гишүүн | |

| | | | |
|---|--|---|--|
| | Хууль эрх зүйн хэлтсийн дарга | | <ul style="list-style-type: none"> - Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах - Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах; - Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах. - Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна. - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах - Хурал зарласан үед яаралтай заагдсан газар ирэх |
| 8 | Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн боллого төлөвлөт, хөрөн оруулалтын хэлтсийн дарга | Онцгой комиссын гишүүн, уул уурхайн албаны дарга, Төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан туслах | <ul style="list-style-type: none"> - Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах - Онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж, бэлэн байдлыг хангах - Гамшгийн голомтод шаардлагатай өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах - Аймгийн хэмжээнд уул уурхайн албыг удирдлагаар ханган, гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах - Онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу урьдчилан сэргийлэх ажлыг удирдлагаар ханган зохион байгуулах - Гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах; - Орон нутагт ажиллахдаа тухайн сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах. - Онцгой комиссын гишүүн нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг Онцгой комисст танилцуулна. - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлаа хангах - Хурал зарласан үед яаралтай заагдсан газар ирэх |
| 9 | Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын | Онцгой комиссын гишүүн | <ul style="list-style-type: none"> - Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах |

| | | |
|----|--|---|
